



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон
гүйцэтгэгч томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.9, 76.1.18, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, “Монголын хөрөнгийн бирж” ХК (“Компани” гэх)-ийн “Дүрэм”-ийн 5.7.8, 5.7.9, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.5.4, 2.8.1, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тамираа овогтой Хаш-Эрдэнийг 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Компанийн Гүйцэтгэх захирлыг томилох хүртэл хугацаанд Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.
2. Т.Хаш-Эрдэнэтэй байгуулах “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний загварыг Хавсралтаар баталсугай.
3. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөнийг 2025 оны 10 дүгээр сарын 06-ны өдрөөр тасалбар болгон албан тушаалаас чөлөөлсөнтэй холбоотойгоор түүний үүрэгт ажлыг Т.Хаш-Эрдэнэд 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр хүлээлцүүлж, энэхүү тогтоолын хавсралтаар баталсан гэрээг байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.
4. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Хаш-Эрдэнийн сарын үндсэн цалинг 7,000,000 (долоон сая) төгрөгөөр тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч (Б.Оюун)-д зөвшөөрсүгэй.
5. Бизнес хөгжлийн газрын захирлын үүргийг Хяналт, зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалангаар хавсран гүйцэтгүүлсүгэй.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нэр дэвшүүлэх хороо (Н.Отгончимэг)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525010120



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

Б.Дөлгөөнийг албан тушаалаас
чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, “Монголын хөрөнгийн бирж” ХК (“Компани” гэх)-ийн “Дүрэм”-ийн 5.7.8, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.5.4, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулсан 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний 6.1.3, 6.2.2, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөний 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баасандаваа овогтой Дөлгөөний өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийн дагуу түүнийг 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөр тасалбар болгон Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалаас чөлөөлж, түүнтэй байгуулсан “Хөлсөөр ажиллах гэрээ”-г дуусгавар болгосугай.
2. Б.Дөлгөөнд үүрэгт ажлаа 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөр тасалбар болгон ажил хүлээлцэх акт үйлдэн хүлээлгэж өгөхийг үүрэг болгосугай.
3. Б.Дөлгөөнийг албан тушаалаас чөлөөлсөнтэй холбоотойгоор цалин хөлс, ээлжийн амралт, эд хөрөнгийн тооцоог дуусгавар болгохыг олгохыг Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч (Б.Оюун)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нэр дэвшүүлэх хороо (Н.Отгончимэг)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525010125